

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин		Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
				Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
	1	2	3			6	7
НЗД-ын ҮАХ-ийн Зорилго 2.1. "Хот, суурин газрыг дахин төлөвлөн хөгжүүлж, төвлөрлийг сааруулах замаар иргэдийн амьдрах орчныг сайжруулна."							
Зорилт 1. "Хотын хөгжлийн индексийн үзүүлэлтэд үндэслэн дүүрэгт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа 2050", Улаанбаатар хотыг хөгжүүлэх богино, дунд, урт хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах."							
1.	Арга хэмжээ 1.1. Хороодоос хотын хөгжлийн индексийн тоо, мэдээг хүлээн авч, хянан холбогдох байгууллагад баталгаажуулж хүргүүлнэ.	Тоо, мэдээг хугацаанд нь тайлагнасан байна.	-	2024 оны мэдээг хороодоос хүлээн авч, хяналт тавина.	2024 оны мэдээг хороодоос хүлээн авч, хянан холбогдох байгууллагад хүргүүлнэ.	01	12
2.	Арга хэмжээ 1.2. Хотын хөгжлийн индексийн асуудлаар хороодын албан хаагчдыг чадавхжуулах, мэргэжил арга зүйгээр хангана.	1-ээс доошгүй удаа сургалтад хамруулж, тухай бүр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө.	Хорооны 50 албан хаагчийг сургалтад хамруулсан.	Тухай бүр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө.	1 удаа сургалтад хамруулна.	01	12
ДЗД-ын ҮАХ-ийн Зорилго 2.1. "Төсвийн төлөвлөлтөд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж ил тод нээлттэй байдлыг сайжруулан төсвийн хөрөнгийг үр ашигтай, хариуцлагатай төлөвлөж хэрэгжүүлнэ."							
Зорилт 2. "Орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулгын үр дүнд үндэслэн дүүрэгт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа 2050", Улаанбаатар хотыг хөгжүүлэх богино, дунд, урт хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах."							

3.	Арга хэмжээ 2.1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2026 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд иргэдээс санал авах ажлыг зохион байгуулна.	Иргэдээс ирүүлсэн санал, тоо	2024 онд 90,000 санал авсан.	Санал асуулгыг эхлүүлнэ.	Санал асуулгыг авч, холбогдох байгууллагад хүргүүлнэ.	01	12
4.	Арга хэмжээ 2.2. Төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөн санхүүжүүлэх төсөл, арга хэмжээнд иргэдээс санал авах, тайлагнах үйл ажиллагаанд хороодын албан хаагчдыг чадавхжуулах, мэргэжил арга зүйгээр хангана.	1-ээс доошгүй удаа сургалтад хамруулж, тухай бүр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө.	Хорооны 50 албан хаагчийг сургалтад хамруулсан.	1 удаа сургалтад хамруулна.	-	01	06
5.	Арга хэмжээ 2.3. Дүүргийн 20-22 дугаар байрны зүүн талын авто замын засварын ажлыг эхлүүлнэ. (1 дүгээр хороо)	Авто замын засварын ажил эхэлсэн эсэх	-	Зураг төсвийг хүлээлгэн өгч, худалдан авах ажиллагааг зарлуулсан байна.	Авто замын засвар 100%-тай хэрэгжсэн байна.	01	12
6.	Арга хэмжээ 2.4. Дүүргийн 1 дүгээр хорооны 1, 2 дугаар байрны хойд талын тохижилтын ажлыг хэрэгжүүлнэ. (1 дүгээр хороо)	Тохижилтын ажил хэрэгжсэн эсэх	-	Зураг төсвийг хүлээлгэн өгч, худалдан авах ажиллагааг зарлуулсан байна.	Тохижилтын ажил хэрэгжсэн байна.	01	12
7.	Арга хэмжээ 2.5. Дүүргийн 1 дүгээр хорооны 3, 4 дүгээр байрны дунд талын талбайн тохижилтын ажлыг хэрэгжүүлнэ. (1 дүгээр хороо)	Тохижилтын ажил хэрэгжсэн эсэх	-	Зураг төсвийг хүлээлгэн өгч, худалдан авах ажиллагааг зарлуулсан байна.	Тохижилтын ажил хэрэгжсэн байна.	01	12
8.	Арга хэмжээ 2.6. 19-ийн Үйлчилгээний төв орчмын авто зам, явган зам засварын шинэчлэл, өргөтгөлийн ажлыг эхлүүлнэ. (2 дугаар хороо)	Авто зам, явган зам засварын шинэчлэлийн ажил хэрэгжсэн эсэх	-	Зураг төсвийг хүлээлгэн өгч, худалдан авах ажиллагааг зарлуулсан байна.	Авто зам, явган зам засварын ажил 100%-тай хэрэгжсэн байна.	01	12

9.	Арга хэмжээ 2.7. Хийморь хотхоны хойд талын тохижилтын ажлыг хэрэгжүүлнэ. (2 дугаар хороо)	Тохижилтын ажил хэрэгжсэн эсэх	-	Зураг төсвийг хүлээлгэн өгч, худалдан авах ажиллагааг зарлуулсан байна.	Тохижилтын ажил хэрэгжсэн байна.	01	12
10.	Арга хэмжээ 2.8. Дүүргийн 34 дүгээр сургууль, 12 дугаар цэцэрлэгийг бохирын шугамд холбох ажлыг эхлүүлнэ. (4 дүгээр хороо)	Бохирын шугамд холбох ажил эхэлсэн эсэх.	Зураг төсвийн ажлын явц 70 хувь.	Зураг төсвийг Худалдан авах ажиллагааны албанд хүлээлгэн өгсөн байна.	Бохирын шугамд холбох ажлыг 50%-аас доошгүй хэрэгжүүлнэ.	01	12
11.	Арга хэмжээ 2.9. Дүүргийн 5 дугаар хорооны барилга, 41 дүгээр сургууль, 29, 71, 145 дугаар цэцэрлэгийг бохирын шугамд холбох ажлыг эхлүүлнэ. (5 дугаар хороо)	Бохирын шугамд холбох ажил эхэлсэн эсэх.	Зураг төсвийн ажлын явц 70 хувь.	Зураг төсвийг хүлээлгэн өгч, худалдан авах ажиллагааг зарлуулсан байна.	Бохирын шугамд холбох ажлыг 50%-аас доошгүй хэрэгжүүлнэ.	01	12
12.	Арга хэмжээ 2.10. Тохижилт, явган замын засвар, шинэчлэлтийн ажлыг хэрэгжүүлнэ. (5, 19, 24 дүгээр хороо)	Засвар, шинэчлэлтийн ажил хэрэгжсэн эсэх	-	Зураг төсвийг хүлээлгэн өгч, худалдан авах ажиллагааг зарлуулсан байна.	Тохижилт, явган замын засварын ажил 100%-тай хэрэгжсэн байна.	01	12
13.	Арга хэмжээ 2.11. Нийтийн бие засах газрын барилга, тохижилтын ажлыг хэрэгжүүлнэ. (9 дүгээр хороо)	Тохижилтын ажил хэрэгжсэн эсэх	-	Зураг төсвийг хүлээлгэн өгч, худалдан авах ажиллагааг зарлуулсан байна.	Тохижилтын ажил хэрэгжиж дууссан байна.	01	12
14.	Арга хэмжээ 2.12. 62 дугаар байрны гадна талбайн тохижилтын ажлыг хэрэгжүүлнэ. (10 дугаар хороо)	Тохижилтын ажил хэрэгжсэн эсэх	-	Зураг төсвийг хүлээлгэн өгч, худалдан авах ажиллагааг зарлуулсан байна.	Тохижилтын ажил хэрэгжиж дууссан байна	01	12
15.	Арга хэмжээ 2.13. 7 дугаар хэсгийн тоглоомын талбайн тохижилтын ажлыг хэрэгжүүлнэ. (13 дугаар хороо)	Тохижилтын ажил хэрэгжсэн эсэх	-	Зураг төсвийг хүлээлгэн өгч, худалдан авах ажиллагааг	Тохижилтын ажил хэрэгжиж дууссан байна	01	12

				зарлуулсан байна.			
16.	Арга хэмжээ 2.14. 27 дугаар цэцэрлэгийн дээвэр засварын ажлыг хэрэгжүүлнэ. (20 дугаар хороо)	Засварын ажил хэрэгжсэн эсэх	-	Зураг төсвийг хүлээлгэн өгч, худалдан авах ажиллагааг зарлуулсан байна.	Засварын ажил дууссан байна.	01	12
17.	Арга хэмжээ 2.15. ХААИС-ийн оюутны 2 дугаар дотуур байр орчмын талбайн тохижилтын ажлыг хэрэгжүүлнэ. (22 дугаар хороо)	Тохижилтын ажил хэрэгжсэн эсэх	-	Зураг төсвийг хүлээлгэн өгч, худалдан авах ажиллагааг зарлуулсан байна.	Тохижилтын ажил хэрэгжиж дууссан байна	01	12
18.	Арга хэмжээ 2.16. Сургууль, цэцэрлэг, төсөвт байгууллагуудыг инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг эхлүүлнэ.	Бохирын шугамд холбох ажил эхэлсэн эсэх.	Зураг төсвийн ажлын явц 70 хувь.	Зураг төсвийг хүлээлгэн өгч, худалдан авах ажиллагааг зарлуулсан байна.	Бохирын шугамд холбох ажлыг 50%-аас доошгүй хэрэгжүүлнэ.	01	12
19.	Арга хэмжээ 2.17. Тохижилт бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлнэ. (1, 2, 7, 18, 19, 22, 25 дугаар хороо) Багц-1	Тохижилт бүтээн байгуулалт хэрэгжсэн эсэх	Гүйцэтгэгч шалгараагүй	Худалдан авах ажиллагааг дахин зарлуулсан байна.	Тохижилтын ажил 70%-тай хэрэгжсэн байна.	01	12
20.	Арга хэмжээ 2.18. Тохижилт бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлнэ. (1, 2, 7, 18, 19, 22, 25 дугаар хороо) Багц-2	Тохижилтын ажлыг дуусгасан эсэх	2, 18, 19, 22 дугаар хорооны тохижилтын ажлын явц 90%-тай байна.	Тохижилтын ажлыг үргэлжлүүлнэ.	Тохижилтын ажлыг дуусгана.	01	12
21.	Арга хэмжээ 2.19. Автобусны буудлын засвар тохижилтын ажлыг хэрэгжүүлнэ. (9, 14, 21 дүгээр хороо)	Тохижилт хийгдсэн эсэх	Гүйцэтгэгч шалгараагүй	Худалдан авах ажиллагааг дахин зарлуулсан байна.	Тохижилтын ажлыг 70%-тай хэрэгжүүлсэн байна.	01	12
22.	Арга хэмжээ 2.20. Камержуулалтын ажлыг хэрэгжүүлнэ (1-11, 13-21 дүгээр хороо)	Камержуулалтын ажлыг дуусгасан эсэх	Комисс ажиллах шатанд явц 90%	Камержуулалтын ажлыг үргэлжлүүлнэ.	Камержуулалтын ажлыг дуусгасан байна.	01	12

23.	Арга хэмжээ 2.21. Камержуулалтын ажлыг хэрэгжүүлнэ. (4-10, 12, 13, 14, 16, 21 дүгээр хороо)	Камержуулалтын ажлыг дуусгасан эсэх	Комисс ажиллах шатанд явц 90%	Камержуулалтын ажлыг үргэлжлүүлнэ.	Камержуулалтын ажлыг дуусгасан байна.	01	12
24.	Арга хэмжээ 2.22. Камержуулалтын ажлыг хэрэгжүүлнэ. (1-11, 14-21 дүгээр хороо)	Камержуулалтын ажлыг дуусгасан эсэх	Комисс ажиллах шатанд явц 90%	Камержуулалтын ажлыг үргэлжлүүлнэ.	Камержуулалтын ажлыг дуусгасан байна.	01	12
25.	Арга хэмжээ 2.23. Нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлгийн ажлыг хэрэгжүүлнэ. (2023-2025 он дамжих)	Гэрэлтүүлгийн ажлыг дуусгасан эсэх	Ажлын явц 80%	Гэрэлтүүлгийн ажлыг үргэлжлүүлнэ.	Гэрэлтүүлгийн ажлыг дуусгана.	01	12
26.	Арга хэмжээ 2.24. Хөрөнгө оруулалт, тохижилт, бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлнэ. (2023-2025 он дамжих)	Хөрөнгө оруулалт, тохижилт, бүтээн байгуулалт хэрэгжсэн эсэх	Гүйцэтгэгч шалгараагүй	Худалдан авах ажиллагааг дахин зарлуулсан байна.	Хөрөнгө оруулалт, тохижилт, бүтээн байгуулалт 70%-тай хэрэгжсэн байна.	01	12
ДЗД-ын УАХ-ийн Зорилго 2.1. "Төсвийн төлөвлөлтөд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж ил тод нээлттэй байдлыг сайжруулан төсвийн хөрөнгийг үр ашигтай, хариуцлагатай төлөвлөж хэрэгжүүлнэ."							
Зорилт 3. "Гадаад, дотоодын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг тооцох, тайлагнах."							
27.	Арга хэмжээ 3.1. Хан-Уул дүүрэгт гадаад, дотоодын зээл, тусламжаар хэрэгжиж буй хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрийн шаардлагатай баримт бичгийг тухай бүр бүрдүүлнэ.	Холбогдох баримт бичгийн бүрдлийг хангуулсан эсэх	-	Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрийн шаардлагатай баримт бичгийг тухай бүр бүрдүүлнэ.	Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрийн шаардлагатай баримт бичгийг тухай бүр бүрдүүлнэ.	01	12
Зорилт 4. "Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх."							
28.	Арга хэмжээ 4.1. Боловсруулагдсан баримт бичгийг холбогдох журмын дагуу архивын нэгж үүсгэн, хуулийн хугацаанд хүлээлгэн өгнө.	Хуулийн хугацаанд хүлээлгэн өгсөн эсэх	5 баримт бичгийг ХХНДЖ-ын дагуу төрөлжүүлэн хугацаанд нь шилжүүлсэн.	Баримтыг хугацаанд нь хүлээлгэн өгсөн байна.	-	01	03

29.	Арга хэмжээ 4.2. Ирсэн албан бичгийг холбогдох журмын дагуу хугацаанд нь шийдвэрлэж хариу өгнө.	Ирсэн албан бичгийн тоо, шийдвэрлэлтийн байдал	-	Хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн байна.	Хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн байна.	01	12
30.	Арга хэмжээ 4.3. Өргөдөл, гомдлыг холбогдох журмын дагуу хугацаанд нь шийдвэрлэж хариу өгнө.	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацаа, зөрчил гаргасан эсэх	-	Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь зөрчилгүй шийдвэрлэсэн байна.	Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь зөрчилгүй шийдвэрлэсэн байна.	01	12
31.	Арга хэмжээ 4.4. Удирдлагаас цаг үеийн шинж чанартай өгсөн үүрэг даалгаврыг биелүүлнэ.	Үүрэг даалгаврыг хугацаанд нь хэрэгжүүлсэн эсэх	-	Үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлсэн байна	Үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлсэн байна	01	12
32.	Арга хэмжээ 4.5. Ажлын цагийг үр бүтээлтэй ашиглаж, хоцролт, таслалтгүй ажиллана.	Хоцролт, таслалтгүй ажилласан эсэх	Хоцролт, таслалтгүй ажилласан.	Хоцролт, таслалтгүй ажиллана.	Хоцролт, таслалтгүй ажиллана.	01	12
33.	Арга хэмжээ 4.6. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөж, харилцаа, хандлагын нийтлэг журмыг баримтална.	Ёс зүйн зөрчилгүй ажилласан эсэх	Ёс зүйн зөрчилгүй ажилласан.	Ёс зүйн зөрчилгүй ажиллана.	Ёс зүйн зөрчилгүй ажиллана.	01	12
34.	Арга хэмжээ 4.7. Нийслэл, дүүргээс зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээнд оролцоно.	Олон нийтийн арга хэмжээнд оролцсон эсэх	Байгууллага ас зохион байгуулсан 3 олон нийтийн арга хэмжээнд оролцсон.	Олон нийтийн арга хэмжээнд оролцоно.	Олон нийтийн арга хэмжээнд оролцоно.	01	12

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин		Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
				Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Төрийн албаны тухай хуулийн 29.1-д заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдана.	Хамрагдсан сургалтын тоо	А3 сургалт болон Удирдлагын академиас зохион байгуулсан 5	1-ээс доошгүй сургалтад хамрагдана.	1-ээс доошгүй сургалтад хамрагдана.	01	12

			цахим сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан.				
2.	Арга хэмжээ 2. Албан тушаалын онцлогоос хамааран хууль тогтоомжид заасан зайлшгүй шаардлагатай ур чадварыг мэргэжлийн сургалтын байгууллагаар дамжуулж, эсхүл бие даан суралцаж эзэмшинэ.	Хамрагдсан сургалтын тоо	Байгууллагаас зохион байгуулсан 5 сургалтад хамрагдсан.	2-оос доошгүй сургалтад хамрагдана.	2-оос доошгүй сургалтад хамрагдана.	01	12
3.	Арга хэмжээ 3. Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх хүрээнд Үндэсний бичгийн сургалтад хамрагдана.	Сургалтад хамрагдсан эсэх	1 сургалтад хамрагдсан.	1 сургалтад хамрагдана.	1 сургалтад хамрагдана.	01	12

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

Хотын хөгжлийн индекс, орон
нутгийн хөгжлийн сан, төсөл
хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн

Б.Ариунаа / /


2025.01.02

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын
хэлтсийн дарга

Л.Отгонбаяр: /

2025.01.02



Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ХОТЫН ХӨГЖЛИЙН ИНДЕКС,
ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
БАТ-ЭРДЭНИЙН АРИУНААГИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Хувь
	1	2	3	4	5	6	7
НЗД-ын УАХ-ийн Зорилго 2.1. "Хот, суурин газрыг дахин төлөвлөн хөгжүүлж, төвлөрлийг сааруулах замаар иргэдийн амьдрах орчныг сайжруулна."							
Зорилт 1. "Хотын хөгжлийн индексийн үзүүлэлтэд үндэслэн дүүрэгт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа 2050", Улаанбаатар хотыг хөгжүүлэх богино, дунд, урт хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах."							
1.	Арга хэмжээ 1.1. Хороодоос хотын хөгжлийн индексийн тоо, мэдээг хүлээн авч, хянан холбогдох байгууллагад баталгаажуулж хүргүүлнэ.	Тоо, мэдээг хугацаанд нь тайлагнасан байна.	-	2024 оны мэдээг хороодоос хүлээн авч, хянан холбогдох байгууллагад хүргүүлнэ.	Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн А/77 дугаар тушаалаар батлагдсан Хотын хөгжлийн индекс тооцох аргачлалын хүрээнд "Хүрээлэн буй орчин", "Дэд бүтэц", Амьжиргааны зохистой түвшин, "Боловсрол", "Эрүүл мэнд", "Хувь хүний аюулгүй байдал" нийт 6 бүлгийн 30 шалгуур үзүүлэлтийг 17 маягтаар 25 хороо тус бүрээс хүлээж авч, http://happycity.mn/ программтай тулгах, нягтлан шалгах ажлууд хийгдэж байна.	2025.01.02- 2025.12.31	90%

2.	Арга хэмжээ 1.2. Хотын хөгжлийн индексийн асуудлаар хороодын албан хаагчдыг чадавхжуулах, мэргэжил арга зүйгээр хангана.	1-ээс доошгүй удаа сургалтад хамруулж, тухай бүр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө.	Хорооны 50 албан хаагчийг сургалтад хамруулсан.	1 удаа сургалтад хамруулна.	Хотын хөгжлийн индексийн 2024 оны үзүүлэлтийг тооцохтой холбогдуулан заавар, зөвлөгөө, анхаарах асуудлын талаар 2025 оны 5 дугаар сарын 07-ны өдөр 25 хорооны 18 зохион байгуулагч, нийгмийн ажилтан нарт Статистикийн хэлтэстэй хамтран сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн бөгөөд индекс тооцоход шаардлагатай арга зүйг тухай бүр өгч байна.	2025.01.02-2025.12.31	100%
ДЗД-ын УАХ-ийн Зорилго 2.1. "Төсвийн төлөвлөлтөд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж ил тод нээлттэй байдлыг сайжруулан төсвийн хөрөнгийг үр ашигтай, хариуцлагатай төлөвлөж хэрэгжүүлнэ."							
Зорилт 2. "Орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулгын үр дүнд үндэслэн дүүрэгт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа 2050", Улаанбаатар хотыг хөгжүүлэх богино, дунд, урт хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах."							
3.	Арга хэмжээ 2.1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2026 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд иргэдээс санал авах ажлыг зохион байгуулна.	Иргэдээс ирүүлсэн санал, тоо	2024 онд 90,000 санал авсан.	Санал асуулгыг авч, холбогдох байгууллагад хүргүүлнэ.	Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2026 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээнд иргэд, олон нийтээс авах санал асуулгыг "Орон нутгийн хөгжлийн сангийн Удирдлагын мэдээллийн систем (www.onhs.mof.gov.mn)", "ОНХС" гар утасны аппликейшн болон "E-mongolia" аппликейшнаар дамжуулан 2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс 6 дугаар	2025.01.02-2025.12.31	100%

					сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулж, дүүргийн хэмжээнд нийт 131197 санал авч, саналын нэгтгэлийг 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 04/1083 дугаар албан бичгээр нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн талаарх иргэдийн саналыг шийдвэр гаргах үйл явцад тусгаж, иргэдийн цахимаар санал асуулгад хамруулах ажлыг идэвхжүүлэх зорилгоор дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн удирдамжаар болзолт уралдааныг хороо, зохион байгуулагч, хэсгийн ахлагчийн дунд зарлаж, хамгийн их санал авсан албан хаагчдад холбогдох урамшууллыг олгож, шагнал гардуулах арга хэмжээг зохион байгуулсан.		
4.	Арга хэмжээ 2.2. Төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөн санхүүжүүлэх төсөл, арга хэмжээнд иргэдээс санал авах,	1-ээс доошгүй удаа сургалтад хамруулж, тухай бүр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө.	Хорооны 50 албан хаагчийг сургалтад хамруулсан.	1 удаа сургалтад хамруулна.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2026 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээнд иргэд, олон нийтээс авах санал асуулгын талаар 2025 оны 5 дугаар сарын 07-ны өдөр 25 хорооны 18 зохион байгуулагчид удирдамж болон	2025.01.02-2025.12.31	100%

	тайлагнах үйл ажиллагаанд хороодын албан хаагчдыг чадавжуулах, мэргэжил арга зүйгээр хангана.				санал асуулга авахтай холбоотой мэдээлэл өгсөн.		
5.	Арга хэмжээ 2.3. Дүүргийн 20-22 дугаар байрны зүүн талын авто замын засварын ажлыг эхлүүлнэ. (1 дүгээр хороо)	Авто замын засварын ажил эхэлсэн эсэх	-	Зураг төсвийг хүлээлгэн өгч, худалдан авах ажиллагааг зарлуулсан байна.	Дүүргийн 1 дүгээр хороо 20-22 дугаар байрны зүүн талын авто замын засварын ажлын зураг, төсвийг "Ангад арвижих" ХХК гүйцэтгэсэн бөгөөд төсөвт өртөг 839.4 сая төгрөг болж магадлалаар батлагдсан. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангаас дүүргийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг төсвийн тодотголоор буурч батлагдсан тул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 09 дүгээр хуралдаанаар хэлэлцэж, тус төсөл, арга хэмжээг хасахаар шийдвэрлэсэн.	2025.01.02- 2025.12.31	-
6.	Арга хэмжээ 2.4. Дүүргийн 1 дүгээр хорооны 1, 2 дугаар байрны хойд талын тохижилтын ажлыг хэрэгжүүлнэ. (1 дүгээр хороо)	Тохижилтын ажил хэрэгжсэн эсэх		Зураг төсвийг хүлээлгэн өгч, худалдан авах ажиллагааг зарлуулсан байна.	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх 1 дүгээр хорооны 1, 2 дугаар байрны хойд талын тохижилтын ажлын зураг, төсвийг 2025 оны 01 дүгээр 20- ны өдөр Худалдан авах ажиллагааны албанд актаар баталгаажуулан хүлээлгэн өгсөн. Худалдан авах ажиллагааг зарлуулан 2025	2025.01.02- 2025.12.31	-

					оны 03 дугаар сарын 12-ны өдөр нээхэд 2 аж ахуйн нэгж материал ирүүлсэн бөгөөд 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр бүх тендерээс татгалзсан. Дахин зарлуулж, 2025 оны 05 дугаар 07-ны өдөр нээхэд аж ахуйн нэгж материал ирүүлээгүй. Нийслэлийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн "Хот дахин хөгжүүлэх үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай" А/851 дугаартай захирамжийн дагуу тус дүүргийн 1 дүгээр хорооны 1 дүгээр байрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжихээр болсон тул тус төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зогсоож, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 09 дүгээр хуралдаанаар хэлэлцэж, тус төсөл, арга хэмжээг хасахаар шийдвэрлэсэн.		
7.	Арга хэмжээ 2.5. Дүүргийн 1 дүгээр хорооны 3, 4 дүгээр байрны дунд талын тохижилтын ажлыг хэрэгжүүлнэ. (1 дүгээр хороо)	Тохижилтын ажил хэрэгжсэн эсэх	-	Зураг төсвийг хүлээлгэн өгч, худалдан авах ажиллагааг зарлуулсан байна.	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх 1 дүгээр хорооны 3, 4 дүгээр байрны дунд талын талбайн тохижилтын ажлын зураг, төсвийг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Худалдан авах ажиллагааны	2025.01.02-2025.12.31	100%

					албанд актаар баталгаажуулан хүлээлгэн өгсөн. Худалдан авах ажиллагааг зарлаж, "Цахир толгойн Орд" ХХК шалгарч, 1100 м.кв талбайд тоглоомын талбай, сагсан бөмбөгийн талбай, чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж бүхий талбайн тохижилтын ажил хэрэгжсэн.		
8.	Арга хэмжээ 2.6. 19-ийн Үйлчилгээний төв орчмын авто зам, явган зам засварын шинэчлэл, өргөтгөлийн ажлыг эхлүүлнэ. (2 дугаар хороо)	Авто зам, явган зам засварын шинэчлэлийн ажил хэрэгжсэн эсэх	-	Зураг төсвийг хүлээлгэн өгч, худалдан авах ажиллагааг зарлуулсан байна.	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх 2 дугаар хорооны үйлчилгээний төв орчмын авто зам, явган зам засварын шинэчлэл, өргөтгөлийн ажлын зураг, төсвийг 2025 оны 01 дүгээр 21-ний өдөр Худалдан авах ажиллагааны албанд актаар баталгаажуулан хүлээлгэн өгсөн. Худалдан авах ажиллагааг зарлуулан, гүйцэтгэгчээр "Хайвэй инженеринг Жи Ар" ХХК шалгарч, хэрэгжиж дууссан. Тус төсөл, арга хэмжээний хүрээнд 215м авто зам, 40 автомашины зогсоолын ажил хэрэгжсэн.	2025.01.02-2025.12.31	100%
9.	Арга хэмжээ 2.7. Хийморь хотхоны хойд талын тохижилтын ажлыг хэрэгжүүлнэ. (2 дугаар хороо)	Тохижилтын ажил хэрэгжсэн эсэх	-	Зураг төсвийг хүлээлгэн өгч, худалдан авах ажиллагааг зарлуулсан байна.	Дүүргийн 2 дугаар хорооны Хийморь хотхоны хойд талын тохижилтын ажлын зураг, төсвийг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Худалдан авах ажиллагааны албанд	2025.01.02-2025.12.31	100%

					актаар баталгаажуулан хүлээлгэн өгсөн. Худалдан авах ажиллагааг зарлуулан, гүйцэтгэгчээр "Тод олз" ХХК шалгарч, 1167 м2 талбайд 25 автомашины зогсоол, тоглоомын талбайн тохижилтын ажил хэрэгжсэн.		
10.	Арга хэмжээ 2.8. Дүүргийн 34 дүгээр сургууль, 12 дугаар цэцэрлэгийг бохирын шугамд холбох ажлыг эхлүүлнэ. (4 дүгээр хороо)	Бохирын шугамд холбох ажил эхэлсэн эсэх.	Зураг төсвийн ажлын явц 70 хувь.	Зураг төсвийг Худалдан авах ажиллагааны албанд хүлээлгэн өгсөн байна.	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангаас дүүргийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг төсвийн тодотголоор буурч батлагдсан тул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 09 дүгээр хуралдаанаар хэлэлцэж, бохирын шугамд холбох ажлуудыг нэгтгэж, "4, 5 дугаар хороо, 12, 34, 145 дугаар цэцэрлэгүүдийг бохирын шугамд холбох ажил (4, 5 дугаар хороо)" өөрчлөн, баталсан. Худалдан авах ажиллагаа 3 удаа зарлагдаж, 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдөр нээнэ.	2025.01.02-2025.12.31	50%
11.	Арга хэмжээ 2.9. Дүүргийн 5 дугаар хорооны барилга, 41 дүгээр сургууль, 29, 71, 145 дугаар цэцэрлэгийг бохирын шугамд холбох ажлыг эхлүүлнэ. (5 дугаар хороо)	Бохирын шугамд холбох ажил эхэлсэн эсэх.	Зураг төсвийн ажлын явц 70 хувь.	Зураг төсвийг хүлээлгэн өгч, худалдан авах ажиллагааг зарлуулсан байна.	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангаас дүүргийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг төсвийн тодотголоор буурч батлагдсан тул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 09 дүгээр хуралдаанаар хэлэлцэж, бохирын шугамд холбох	2025.01.02-2025.12.31	50%

					ажлуудыг нэгтгэж, "4, 5 дугаар хороо, 12, 34, 145 дугаар цэцэрлэгүүдийг бохирын шугамд холбох ажил (4, 5 дугаар хороо)" өөрчлөн, баталсан. Худалдан авах ажиллагаа 3 удаа зарлагдаж, 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдөр нээнэ. 7, 8 дугаар хороо, 60, 41 дүгээр сургууль, 29, 71, 73 дугаар цэцэрлэгийг бохирын шугамд холбох ажлыг дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр, шийдвэрлэсэн.		
12.	Арга хэмжээ 2.10. Тохижилт, явган замын засвар, шинэчлэлтийн ажлыг хэрэгжүүлнэ. (5, 19, 24 дүгээр хороо)	Засвар, шинэчлэлтийн ажил хэрэгжсэн эсэх	-	Зураг төсвийг хүлээлгэн өгч, худалдан авах ажиллагааг зарлуулсан байна.	"Тохижилт, явган замын засвар, шинэчлэлтийн ажил"-ын зураг, төсвийг 2025 оны 01 дүгээр 27-ны өдөр Худалдан авах ажиллагааны албанд актаар баталгаажуулан хүлээлгэн өгсөн. Худалдан авах ажиллагааг зарлуулан, гүйцэтгэгчээр "Соён бат констракшн" ХХК шалгарч, - 5 дугаар хороонд 100м явган хүний зам, авто машины зогсоолын ажил, - 19 дүгээр хороонд 100м явган хүний зам, 5бв байрны гадна талбайд тоглоомын талбайн тохижилт, - 24 дүгээр хороонд Яармагийн гүүрнээс Наадамчдын зам хүртэл 130 м явган хүний замын тохижилтын ажлыг гүйцэтгэсэн.	2025.01.02-2025.12.31	100%

13.	Арга хэмжээ 2.11. Нийтийн бие засах газрын барилга, тохижилтын ажлыг хэрэгжүүлнэ. (9 дүгээр хороо)	Тохижилтын ажил хэрэгжсэн эсэх	-	Зураг төсвийг хүлээлгэн өгч, худалдан авах ажиллагааг зарлуулсан байна.	Дүүргийн 9 дүгээр хороонд хэрэгжих "Нийтийн бие засах газрын барилга, тохижилтын ажил"-ын зураг, төсвийг 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр Худалдан авах ажиллагааны албанд актаар баталгаажуулан хүлээлгэн өгсөн. Худалдан авах ажиллагааг зарлуулан, гүйцэтгэгчээр "МСМ бюлдинг" ХХК шалгарч, нийтийн бие засах газрын барилга, тохижилтын ажил дуусаж, комисс хүлээж авсан	2025.01.02-2025.12.31	100%
14.	Арга хэмжээ 2.12. 62 дугаар байрны гадна талбайн тохижилтын ажлыг хэрэгжүүлнэ. (10 дугаар хороо)	Тохижилтын ажил хэрэгжсэн эсэх	-	Зураг төсвийг хүлээлгэн өгч, худалдан авах ажиллагааг зарлуулсан байна.	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх 10 дугаар хорооны "62 дугаар байрны гадна талбайн тохижилтын ажил"-ын зураг, төсвийг 2025 оны 01 дүгээр 27-ны өдөр Худалдан авах ажиллагааны албанд актаар баталгаажуулан хүлээлгэн өгсөн. Худалдан авах ажиллагааг зарлуулан, гүйцэтгэгчээр "Хянгарконстракшн" ХХК шалгарч, сагсан бөмбөг, хөл бөмбөгийн талбай, тоглоомын талбай, чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж бүхий тохижилтын ажил хэрэгжсэн.	2025.01.02-2025.12.31	100%
15.	Арга хэмжээ 2.13. 7 дугаар хэсгийн	Тохижилтын ажил хэрэгжсэн эсэх	-	Зураг төсвийг хүлээлгэн өгч,	Дүүргийн 13 дугаар хорооны 7 дугаар хэсгийн тоглоомын	2025.01.02-2025.12.31	100%

	тоглоомын талбайн тохижилтын ажлыг хэрэгжүүлнэ. (13 дугаар хороо)			худалдан авах ажиллагааг зарлуулсан байна.	талбайн тохижилтын ажлын зураг, төсвийг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Худалдан авах ажиллагааны албанд актаар баталгаажуулан хүлээлгэн өгсөн. Худалдан авах ажиллагааг зарлуулан, гүйцэтгэгчээр "Байгаль алтай" ХХК шалгарч, сагсан бөмбөгийн талбай, тоглоомын талбай, чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж бүхий тохижилтын ажил хэрэгжсэн.		
16.	Арга хэмжээ 2.14. 27 дугаар цэцэрлэгийн дээвэр засварын ажлыг хэрэгжүүлнэ. (20 дугаар хороо)	Засварын ажил хэрэгжсэн эсэх	-	Зураг төсвийг хүлээлгэн өгч, худалдан авах ажиллагааг зарлуулсан байна.	Дүүргийн 20 дугаар хорооны 27 дугаар цэцэрлэгийн дээвэр засварын ажил"-ын зураг, төсвийг 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр Худалдан авах ажиллагааны албанд актаар баталгаажуулан хүлээлгэн өгсөн. Гүйцэтгэгчээр "Тод Олз" ХХК шалгарч, дээвэр засварын ажил хэрэгжиж, 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр комисс ажиллан, хүлээж авсан.	2025.01.02-2025.12.31	100%
17.	Арга хэмжээ 2.15. ХААИС-ийн оюутны 2 дугаар дотуур байр орчмын талбайн тохижилтын ажлыг хэрэгжүүлнэ. (22 дугаар хороо)	Тохижилтын ажил хэрэгжсэн эсэх	-	Зураг төсвийг хүлээлгэн өгч, худалдан авах ажиллагааг зарлуулсан байна.	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх 22 дугаар хорооны "ХААИС-ийн оюутны 2 дугаар дотуур байр орчмын талбайн тохижилтын ажил"-ын зураг, төсвийг 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр Худалдан авах ажиллагааны	2025.01.02-2025.12.31	100%

					албанд актаар баталгаажуулан хүлээлгэн өгсөн. Гүйцэтгэгчээр "Киото Хайвэй" ХХК шалгарч, 2505 м2 авто зам, 56 автомашины зогсоолын ажил хэрэгжсэн.		
18.	Арга хэмжээ 2.16. Сургууль, цэцэрлэг, төсөвт байгууллагуудыг инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг эхлүүлнэ.	Бохирын шугамд холбох ажил эхэлсэн эсэх.	Зураг төсвийн ажлын явц 70 хувь.	Зураг төсвийг хүлээлгэн өгч, худалдан авах ажиллагааг зарлуулсан байна.	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангаас дүүргийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг төсвийн тодотголоор буурч батлагдсан тул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 09 дүгээр хуралдаанаар хэлэлцэж, бохирын шугамд холбох ажлуудыг нэгтгэж, "4, 5 дугаар хороо, 12, 34, 145 дугаар цэцэрлэгүүдийг бохирын шугамд холбох ажил (4, 5 дугаар хороо)" өөрчлөн, баталсан. Худалдан авах ажиллагаа 3 удаа зарлагдаж, 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдөр нээнэ. 7, 8 дугаар хороо, 60, 41 дүгээр сургууль, 29, 71, 73 дугаар цэцэрлэгийг бохирын шугамд холбох ажлыг дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр, шийдвэрлэсэн.	2025.01.02-2025.12.31	-
19.	Арга хэмжээ 2.17. Тохижилт бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлнэ. (1, 2, 7, 18, 19, 22, 25	Тохижилт бүтээн байгуулалт хэрэгжсэн эсэх	Гүйцэтгэгч шалгараагүй.	Худалдан авах ажиллагааг дахин зарлуулсан байна.	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024-2025 он дамжин санхүүжиж буй тохижилт, бүтээн байгуулалтын ажил (1, 2, 7, 18, 19, 22, 25 дугаар	2025.01.02-2025.12.31	40%

	дугаар хороо) Багц-1				хороо) Багц-1 ажлын зураг, төсөв боловсруулах ажлын даалгаврыг Худалдан авах ажиллагааны албанд хүлээлгэн өгч, гүйцэтгэгчээр "Шүрэнгоёл" ХХК шалгаран, түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгөөр гэрээ байгуулж, зураг, төсөв боловсруулах шатанд байна. Тус төсөл, арга хэмжээний хүрээнд: -1 дүгээр хороо 40, 41, 42 дугаар байрны дунд талын сагсан бөмбөгийн талбай засварлах, -7 дугаар хороо Жаргалант 18 дугаар гудамжны тоглоомын талбайн засвар, -25 дугаар хороо Буянт-Ухаа -1 хороолол доторх тоглоомын талбайн засварын ажил хэрэгжинэ.		
20.	Арга хэмжээ 2.18. Тохижилт бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлнэ. (1, 2, 7, 18, 19, 22, 25 дугаар хороо) Багц-2	Тохижилтын ажлыг үргэлжлүүлсэн эсэх	2, 18, 19, 22 дугаар хорооны тохижилтын ажлын явц 90%-тай байна.	Тохижилтын ажлыг үргэлжлүүлнэ.	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024-2025 он дамжин хэрэгжиж буй тохижилт бүтээн байгуулалтын ажил (1, 2, 7, 18, 19, 22, 25 дугаар хороо) Багц-2 ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэн, 2025 оны 05 дугаар 29-ний өдөр комисс хүлээж авсан. Үүнд: - 2 дугаар хороо Жаргалант үйлчилгээний төвийн шатны засвар, шинэчлэлийн ажил - 22 дугаар хороо Хөдөө аж ахуйн их сургуулийн 1, 3 дугаар	2025.01.02-2025.12.31	100%

					байрны орчмын авто замын засварын ажил - 19 дүгээр хороо 70а байрны урд зогсоолын ажил - 18 дугаар хороо Хүннү 2222 хорооллын урд автобусны дулаан буудал байгуулах ажлууд хэрэгжсэн.		
21.	Арга хэмжээ 2.19. Автобусны буудлын засвар тохижилтын ажлыг хэрэгжүүлнэ. (9, 14, 21 дүгээр хороо)	Худалдан авах ажиллагааг зарлуулсан эсэх	Гүйцэтгэгч шалгараагүй.	Худалдан авах ажиллагааг дахин зарлуулсан байна.	Дүүргийн 9, 10, 14, 21 дүгээр хороонд шинээр 5 байршилд автобусны буудал байгуулах тохижилтын ажлын зураг, төсвийг "Гипотенуз дизайн" ХХК гүйцэтгэж, зураг төсвийг магадлалаар батлуулсан. Тус ажлын батлагдсан төсөвт өртөг Барилгын хөгжлийн төвийн магадлалын нэгдсэн дүгнэлтээр буурч батлагдсан тул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 09 дүгээр хуралдаанаар хэлэлцэж, төсөвт өртгийг өөрчлөн баталсан. Худалдан авах ажиллагааг зарлаж, "Грейдерийн хүч рөүд" ХХК-д гэрээ байгуулах эрх олгогдсон.	2025.01.02-2025.12.31	70%
22.	Арга хэмжээ 2.20. Камержуулалтын ажлыг хэрэгжүүлнэ (1-11, 13-21 дүгээр хороо)	Камержуулалтын ажлыг үргэлжлүүлсэн эсэх	Ажлын явц 80%	Камержуулалтын ажлыг үргэлжлүүлнэ.	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024-2025 он дамжин санхүүжиж байгаа камержуулалтын ажлын гүйцэтгэгчээр "Арш технологи" ХХК ажиллаж байгаа бөгөөд угсралтын ажлын гүйцэтгэл 90%-тай. Шилэн кабелийн трассын дагуу хэмжилт	2025.01.02-2025.12.31	90%

					туршилт, тасарсан кабель, шугамыг холбох, Цагдаагийн 1 дүгээр хэлтэст цэгүүдийг асааж, шалгах ажлууд хийгдэж байна. Тус төсөл, арга хэмжээний хүрээнд 1, 2, 3, 4, 5, 9, 10, 11, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21 дүгээр хороодын 37 цэгт нийт 114 ширхэг чиглэлийн камер, 5 ширхэг хөдөлгөөнт камер суурилуулна. Ажлын явц 90%-тай байна.		
